



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Шалгуур, дүгнэх аргачлал
батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа тусгай зөвшөөрлийн комиссын 2013 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдийн ажлын байр, бүрдүүлсэн баримт бичгийг үнэлэх шалгуур, дүгнэх аргачлалыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаалаар батлагдсан шалгуур, дүгнэх аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг орон нутаг дахь эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын дарга нарт үүрэг болгосугай.
3. Уг тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын даргад даалгасугай.



САЙД

Г.ШИЙЛЭГДАМБА

Эрүүл мэнд, спортын сайдын
2014 оны 12 сарын 26 өдрийн
19 дугаар тушаалын хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛ /ЭМНЭЛЭГ, СУВИЛАЛ, ЛАБОРАТОРИ, АРИУТГАЛ,
ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН БОДИС ИМПОРТЛОХ, ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ,
ХУДАЛДАХ/-ЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХОД ТАВИГДАХ ШАЛГУУР**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.12 дахь заалтын 15.12.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 заалтанд заасан эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгоход энэхүү шалгуурыг мөрдлөг болгоно.

1.2. Энэхүү шалгуур нь хуулиар тогтоосон тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага (цаашид “Эрх бүхий байгууллага” гэх)-аас томилогдсон комисс, түүний ажлын алба, шинжээчийн баг болон тусгай зөвшөөрөл хүсэгчдэд хамаарна.

1.3. Тусгай зөвшөөрөл хүсэгчийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага байгуулах (цаашид “Эрүүл мэндийн байгууллага” гэх) хэрэгцээ шаардлага нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход баримтлах тэргүүлэх чиглэлтэй нийцсэн байна.

1.4. Тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3, мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх, 21.3 дахь заалтын дагуу материал бүрдүүлж ажлын албанд ирүүлнэ.

Хоёр. Шалгуураар үнэлэх аргачлал

2.1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход тавих шалгуур ерөнхий, өвөрмөц гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.

2.2. Ерөнхий шалгуур нь тухайн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтын холбогдолтой шалгуур байна.

2.3. Өвөрмөц шалгуур тухайн байгууллагын тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангасныг илтгэх шалгуур байна.

2.4. Ерөнхий шалгуур нь бүх эрүүл мэндийн байгууллагад ижил байна.

2.5. Тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээд /Цаашид “тусгай зөвшөөрөл хүсэгч” гэх /-ийн ажлын байр, баримт бичигт үнэлгээ хийхдээ шалгуур үзүүлэлт бүрийг тухайн тусгай зөвшөөрөл хүсэгчийн эрүүл мэндийн чиглэлээр эрхлэх мэргэжлийн үйл ажиллагааны төрөл, чиглэлээс хамааран холбогдох стандарт, хууль түүнийг дагалдан гарсан журам, заавар, удирдамжийг баримтлан “хангасан”, “хангаагүй” гэж үнэлнэ.

2.6. Шинжээчийн баг нь шалгуур үзүүлэлтийн үнэлгээг үндэслэн дүгнэлт гаргана.

2.7. Шинжээчийн багийн дүгнэлтийг эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын хурлаар хэлэлцүүлнэ.

2.8. Шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан “тусгай зөвшөөрөл хүсэгч”-д Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тусгай зөвшөөрлийн комиссын хурлын шийдвэрийг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.


Гурав. Шалгуур

№	Хууль, стандарт, тогтоол, дүрэм, журам	Шалгуурууд	Шинжээчийн үнэлгээ		Тайлбар
			Хангасан	Хангаагүй	
Ерөнхий үзүүлэлт					
1	"Чиглэл батлах тухай" салбарын сайдын тушаалаар дэмжих чиглэлд нийцсэн байх	2014-2016 онд Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дэмжих чиглэлд орсон байх			
2	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-ийн 11.1.1-11.1.5 дах заалт	тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, үйлдвэрлэл үйлчилгээний онцлогоос шалтгаалан хуульд заасан бусад баримт бичиг			


3		Үүсгэн байгуулагчийн шийдвэр			
4	Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дах заалт	Эрүүл мэндийн байгууллагын дүрэм, үзүүлэх тусламж, үйлчилгээний чиглэл, хүчин чадал, тооцоо, эрүүл мэндийн байгууллага байгуулах үндэслэл, санхүүгийн тооцоо			
5		Эрүүл мэндийн байгууллага нь дүрэмтэй байна.			
6	Эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, мөн хуулийн 21.3-ийн 21.3.1-21.3.4 дэх заалтууд	Байгууллагын үндсэн зорилго, чиг үүрэг, удирдах бүрэлдэхүүн, түүний эрх хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгийн зарцуулалтын талаар тусгасан байна.			
7	“Эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага”-д нийцсэн байх	Үүсгэн байгуулагчийн талаархи мэдээллийг холбогдох тушаалын дагуу гаргасан байна.			
8		Хүний нөөцийн мэдээллийг тушаалын дагуу гаргасан байна.			
9		Тоног төхөөрмжийн жагсаалтыг холбогдох тушаалын дагуу гаргасан байна.			
10	Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол	"Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг мөрдөж ажиллахаар судалсан байна.			

11	Хөдөлмөрийн тухай хуулийн 24 дүгээр зүйл, мөн хуулийн 48 дүгээр зүйлийн 48.3-ын 48.3.1-48.3.4 дэх заалтууд	Хуулинд нийцүүлэн ажил, албан тушаалын жагсаалт, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн норм, норматив, үндсэн цалингийн сүлжээ, жишиг болон нэмэгдэл хөлс, нэмэгдлийн хэмжээ, шагнал урамшуулал, түүнийг олгох нөхцөл журам, ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ байгуулсан байна.			
Өвөрмөц үзүүлэлт					
12	Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дах хэсэг Монгол улсын стандарт Эрүүлийг хамгаалах технологи стандартууд болон түүний холбогдох заалтын шаардлагыг хангасан байх	Өөрийн байгууллагын үйл ажиллагааны чиглэлд тохирсон түгээмэл үйлдлийн стандартыг мөрдөн ажиллах шаардлагыг хангасан байна.			
13	Эрүүлийг хамгаалах технологи стандартууд болон түүний холбогдох заалтын шаардлагыг хангасан байх	Өөрийн байгууллагын үйл ажиллагааны чиглэлд тохирсон эмнэлзүйн заавар журам, аргачлалыг гаргаж өөрийн байгууллагын даргаар батлуулж хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.			
14		Тухайн чиглэлээр үндсэн, болон төрөлжсөн мэргэжил эзэмшсэн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээр бүрэн хангагдсан байна.			
15	Эрүүлийг хамгаалах технологи стандартад заасан орон тоогоор хангасан байх	Тухайн чиглэлээр мэргэшсэн сувилагч, тусгай мэргэжилтнүүдээр бүрэн хангагдсан байна.			
16		Тухайн байгууллагын хэлийн үйл ажиллагааг хангахад шаардагдах орон тоогоор хангагдсан байна.			





17	Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь заалт	Эмнэлгийн тусламж, үйлчилгээг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий эмнэлгийн мэргэжилтэн үзүүлнэ			
18	Өөрийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг батлагдсан маягтын дагуу гаргах	Шаардлагатай анхан шатны маягтаар бүрэн хангагдсан байна			
19	Эрүүл мэндийн байгууллагын халдварын сэргийлэлт, хяналт, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх үйл ажиллагааг холбогдох эрх зүйн актын дагуу зохион байгуулсан байх	Эрүүл мэндийн байгууллагад хийгдэх халдварын сэргийлэлт, хяналтын зохион байгуулалт, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварыг бүртгэх, мэдээлэх үйл ажиллагааг холбогдох журам, зааврын дагуу зохион байгуулсан байна.			
20	Тусламж үйлчилгээ үзүүлэгчид болон үйлчлүүлэгчдийн аюулгүй, эрсдэлгүй байдлыг хангах ажлыг холбогдох тушаалын дагуу зохион байгуулсан байх	Гар угаах, халдваргүйжүүлэх зааврыг хэрэгжүүлэх нөхцөл боломжоор бүрэн хангасан байна.			
21		Цэвэрлэгээ хийхэд шаардлагатай хувийн хамгаалах хэрэгсэл, багаж хэрэгсэл, цэвэрлэгээний материалыг угааж хадгалах нөхцөлөөр бүрэн хангасан байна			
22		Эрүүл мэндийн байгууллагад давтан хэрэглэгддэг эмнэлгийн багаж хэрэгслийг угаах, ариутгах, халдваргүйжүүлэх зааврыг хэрэгжүүлэх нөхцөл боломжоор бүрэн хангасан байна.			



23		Эрүүл мэндийн ажилтан нь ажил үүргээ гүйцэтгэх явцад халдварт өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, халдварт өртсөний дараа урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хянах үйл ажиллагааг зааврын дагуу зохион байгуулсан байна.		
24		Шаардлага хангасан тусгаарлах тасаг, өрөөтэй байна.		
25		Орны тоо, хүчин чадалдаа тохирсон зөөлөн эдлэл, цагаан хэрэглэл, Эрүүл мэндийн ажилтны ажлын хувцас угаах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байна.		
26		Үзүүлэх тусламж үйлчилгээний чиглэлээс хамааран үйлчилгээ үзүүлэгчид болон үйлчлүүлэгчдийн аюулгүй, эрсдэлгүй байдлыг хангах нөхцөл бололцоог бүрэн хангасан байна.		
27		Үйлчлүүлэгчээс, эмнэлгийн ажилтанд, эмнэлгийн ажилтнаас үйлчлүүлэгчдэд, үйлчлүүлэгчдийн дунд эмнэлгийн ажилтнаар дамжин бичил биетэн тархахаас хамгаалах нөхцөлийн бүрэн бүрдүүлсэн байна.		
28	Хог хаягдлын тухай хуулийн 9.2, 9.3, 9.4-р заалт болон уг	Аюултай хог хаягдлын хогийн сав нь таглаатай, хөлөөрөө дарж онгойдог.		



29	заалттай холбогдон гарсан тушаал зааврыг хангах ажлыг зохион байгуулах	Хогийн савны 2/3-т "Анхаар" гэсэн тэмдэглэгээтэй.			
30		Хог хаягдалтай уут савыг тодорхой нэг газар байршуулж, хаягдлыг ангилан ялгах заавар, санамжийг бичиж тавьсан байна.			
31		Аюултай болон ердийн хог хаягдлыг зориулалтын, таних тэмдэгтэй, шаардлага хангасан уут, саванд ангилан ялгана.			
32		Хог хаягдлыг түр хадгалах байранд аюулгүйгээр хадгалж, нэгдсэн байгууламжид хүлээлгэн өгнө.			
33		Шингэн хог хаягдлыг урьдчилан хоргүйжүүлж, саармагжуулж халдваргүйтгэсний дараа төвлөрсөн бохирын шугамд нийлүүлнэ.			
34	Хог хаягдлын тухай хуулийн 9.2.6	Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан биелэлтийг хангаж ажиллана.			